



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар
Анагаах Ухааны Сургууль

Хөтөлбөрийн нэр: Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөр

Шинжээчийн баг:

Ахлагч: : Б.Оюунбат, Этүгэн Их Сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн захирал

Гишүүд: Ц.Ганцэцэг, Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн сувилахуйн сургуулийн
ахлах багш

Ц.Амаржаргал, Улсын 1-р төв эмнэлгийн сувилахуйн албаны дарга

2024 он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

| | |
|--------|--|
| ААН | Аж ахуйн нэгж |
| АУС | Анагаах Ухааны Сургууль |
| АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль |
| АУ | Анагаах ухаан |
| БМИҮЗ | Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |
| БОЭТ | Бүсийн оношилгоо эмчилгээний төв |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| БЗДХ | Бэлгийн замаар дамжих халдвар |
| БСШУС | Боловсрол соёл шинжлэх ухааны сайд |
| БНХАУ | Бүгд найрамдах Хятад ард улс |
| БЗДХ | Бэлгийн замаар дамжих халдвар |
| БС | Боловсрол судлал |
| БУ | Боловсролын ухаан |
| ДБУМС | Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем |
| ДОХ | Дархлалын олдмол хомс |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЗХШҮА | Захиргаа хяналт шинжилгээ үнэлгээний алба |
| МУ | Монгол Улс |
| НЭ | Нэгдсэн эмнэлэг |
| НЭМШУ | Нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухаан |
| ОУБИС | Олон улсын боловсролын их сургууль |
| ОХУ | Оросын холбооны улс |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| СБЗА | Сургалтын бодлого зохицуулалтын алба |
| ТУ | Төрийн удирдлага |
| УАУ | Уламжлалт анагаах ухаан |
| УЗ | Удирдах зөвлөл |
| ХШУ | Хэлний шинжлэх ухаан |
| ЧХХ | Чих хамар хоолой |
| ЭЕШ | Элсэлтийн ерөнхий шалгалт |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЭМБУ | Эрүүл мэндийн боловсролын удирдлага |
| IF | Impact factor |
| HEMIS | Higher Education Management Information System |
| ISO | International Organization for Standardization |
| GNB | General Nurse Bachelor |
| GND | General Nurse Diploma |

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|---|---|---|
| Сургуулийн нэр /Монгол, Англи/ | АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль Dornogovi Medical School of MNUMS | |
| Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/ | Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөр Nursing program with Bachelor's degree | |
| Шинжээчид | 1.Б.Оюунбат, ЭИС-ийн Нүүр ам судлалын сургуулийн захирал, АУ-ны док. проф. 2.Ц.Ганцэцэг, Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн сувилахуйн сургуулийн ахлах багш, АУ-ны магистр 3. Ц.Амаржаргал, Улсын 1-р төв эмнэлгийн сувилахуйн албаны дарга, сувилахуйн ухааны магистр | |
| БМИҮЗ-ийн Мэргэжилтэн | Н.Түмэнжаргал | |
| Төлөвлөгөө | Он сар өдөр | Хийгдсэн байх ажлууд |
| | 2024. 01.08 | Сургуулийн орчинтой танилцах |
| | | Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах |
| | | Оюутнуудын төлөөлөлтэй уулзах |
| | | Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/ |
| | 2024. 01.09 | Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/ |
| Багш нартай уулзах | | |
| Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах | | |
| Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн үрьдчилсан дүгнэлтийг байгүүллэгэд мэдэгдэнэ. | | |
| Шалгуур шаардлага /журам/ | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага” | |

I. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Тус сургууль 1962 онд байгуулагдсан ба 2022-2023 оны хичээлийн жилд 60 дахь удаагийн элсэлтээ авч, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулж байна. 1966 онд анхны сувилагчийн анги нээгдэж, сургалтаа явуулж эхэлсэн.

- 1968-1994 он хүртэл “Сувилагч” мэргэжлээр төгсгөсөн.
- 1995-2012 онд “Сувилагч” мэргэжлээс гадна “Бага эмч-сувилагч” мэргэжлээр 3 жилийн дипломын төгсөлт хийсэн.
- 1995 оноос эхлэн “Сувилахуй” 4 жилийн бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.
- 2013 оноос ЭМШУИС-ийн сургалтын нэгдсэн хөтөлбөр, “Нэг хөтөлбөр-нэгдсэн агуулга” хөтөлбөрийн нэгдсэн шинэчлэл хийсэн.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- ДЭМБ-ын зөвлөснөөр эмч-сувилагчийн харьцаа 1:3 байх нь зохистой гэж үздэг. Монгол улсад Эрүүл мэндийн салбарт 13112 сувилагч ажилладаг ба 10000 хүн амд 40,7 сувилагч ноогдож байгаа ба 90% нь эмэгтэйчүүд эзэлж байна. Эмч-сувилагчийн харьцаа 1:1,1 байна. Зүүн болон говийн бүсийн аймгуудад 10000 хүн амд 32,8 сувилагч ноогдож эмч-сувилагчийн харьцаа 1:1,15 байгаа нь сувилахуйн мэргэжилтэн хангалтгүй байгааг харуулж байна. Энэ хэрэгцээг хангахын тулд жил бүр Сувилахуйн мэргэжлийг сонгон суралцах оюутны тоо жил бүр нэмэгдсэн байна.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийг дотоодын Этүгэн их сургууль, Энэрэл дээд сургууль, гадаадын Япон улсын Шизоука мужийн их сургуулийн Сувилахуйн сургууль, ОХУ-ын Санкт-Петербург хотын Сувилахуйн сургууль зэрэг 4 сургуулийн сургалтын хөтөлбөртэй харьцуулан судалжээ. Дотоодын Этүгэн их сургууль, Энэрэл дээд сургуулийн Сувилахуйн бакалавр мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын хөтөлбөртэй агуулгын хувьд ижил байна.

Онцлог зүйл:

- Сувилахуйн мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж төгссөн зүүн болон говийн бүсийн сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо-эмчилгээний төвд

ажиллаж буй төгсөгчдөөс 2018, 2021, 2023 онуудад судалгаа авч сургалтын хөтөлбөрийн чанар, хэрэгжилтэд 72,3% -оос 80% тул хангалттай гэж дүгнэжээ. Үүнд:

1. Төгсөгчдөөс авах санал асуулгын хуудас
2. Багш нараас авах санал асуулгын хуудас
3. Сувилахуйн ангийн оюутнуудаас авах санал асуулгын хуудас

- Дорноговь аймаг дахь АУС нь АШУҮИС-ийн Сувилахуйн бакалавр бэлтгэдэг сургалтын төлөвлөгөөг дотоодын 2, гадаадын 2 сургуулийн сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан нь сайн байна.

Анхаарах асуудал:

- Сувилахуйн бакалаврын сургалтын төлөвлөгөө нь 2016 онд буюу 8 жилийн өмнө батлагдсан АШУҮИС-ийн Сувилахуйн сургалтын төлөвлөгөөгөөр сургалт явагдаж байна.

Дүгнэлт:

- Зүүн болон говийн бүсийн аймгуудад сувилахуйн мэргэжилтэн хангалтгүй байгаатай уялдуулан оюутны элсэлтийн тоо жил бүр бага багаар нэмэгдэж байгаа нь сайшаалтай боловч цаашид энэ тоог шаардлагатай хэмжээнд хүргэх нь зүйтэй.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөө ижил мэргэжлийн 4 их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан нь сайшаалтай.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зүүн болон говийн бүсийн аймгуудад дутагдаж буй Сувилахуйн мэргэжилтнийг бэлтгэх гол баз нь Дорноговь аймаг дахь 62 жилийн түүхтэй АУС юм. Иймд нөөц боломжоо ашиглан, сургалт сурталчилгаа сайн хийж оюутны элсэлтээ нэмэгдүүлэх нь зүйтэй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн зорилгыг “Сувилахуйн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд чиглэсэн сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, бүх шатлалын эмнэлэг, сургууль, цэцэрлэг урьдчилан

сэргийлэх байгууллагуудад ажиллахаар бэлтгэхэд оршино гэж АШУҮИС-ийн зорилго, өөрийн сургуулийн эрхэм зорилготой уялдуулан тодорхойлж зорилтуудаа дэвшүүлсэн байна.

- Ирээдүйн сувилахуйн мэргэжилтэн нь суралцах хугацаандаа мэргэжлийн чиглэлээр 2631 төрлийн онолын мэдлэг, 3046 чадвар эзэмшин, 2568 хандлагыг олон удаагийн давтамжтайгаар төлөвшүүлсэн судалгаа байгаа нь бусад ижил төрлийн сургуультай харьцуулахад илүү байна. Дээрхи мэдлэг, чадвар, хандлагыг байнга төлөвшүүлэхийн тулд суралцагч 1, 2, 3-р дамжааны оюутнууд, үйлчлүүлэгчид болон ажил олгогч нараас сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлгээ хийжээ.

Онцлог зүйл:

- Олон улсын жишигт ойртсон Сувилахуйн бакалаврын сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зорилгоор АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, Говь-Алтай, Дархан-уул аймаг дахь салбар АУС-ийн багш нартай хамтран сувилагч бэлтгэх сургалтын цөм төлөвлөгөөг “Нэгдмэл орчин- Нэг стандарт” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа нь бусад сургуулиудад хэрэгжээгүй шинэлэг ажил байна.
- Сувилагч мэргэжлээр төгсөгч нь нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг баримталдаг, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган, чанарыг эрхэмлэсэн, манлайлагч, багаар хамтран ажиллах чадвар бүхий цогц чадамжтай байна гэж мэргэжилтний чадамжийг тодорхойлсон нь олон улсын жишигт ойртсон байна.

Дүгнэлт:

- Сувилахуйн мэргэжилтний цогц чадамж буюу Blue print дээр үндэслэн чадамжийн түвшинг ашигласнаар оюутны хүрэх түвшин, үр дүн нь тодорхой болж сурах идэвхийг нэмэгдүүлж төгсөгчдийн сурлагын амжилт, чанар жил бүр дээшилснээр харагдаж байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн үнэлгээнээс үзэхэд төгсөгчдийн харилцаа хандлагад хангалтгүй үнэлгээ өгсөн нь цаашид хөтөлбөртөө харилцааны ур чадвар хичээлийг илүү анхаарах нь зүйтэй. Тус сургуульд харилцааны ур чадвар хичээл 1 кр зааж байгаа нь ижил төстэй сургуулиудаас бага байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн захирлын 2022 оны 04 сарын 14-ний өдрийн А/29 тоот тушаалаар хөтөлбөрийн дэд хороо 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Сургалтын хөтөлбөрийг БШУЯ-ны сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 тоот тушаалд заасны дагуу шинэчлэн боловсруулсан байна. 2019-2023 онуудад нийт 77 хичээлийн хөтөлбөрт шинэчлэл сайжруулалт хийснийг харж үнэллээ.

Онцлог зүйл:

- Сувилахуй бакалаврын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 1-10 боть болгон хэвлүүлсэн байна. Уг 10 ботьд хичээлийн нэр, индекс, хичээлийн зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн, тухайн хичээлээр олгох мэдлэг, чадвар, хандлага, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг үнэлгээ зэргийг товч тодорхой бичсэн нь онцлог байлаа.

Дүгнэлт:

- Хичээлийн хөтөлбөрүүд болон баримт бичгүүд эмх цэгцтэй, бусад сургуулиудад үлгэр жишээ болохуйц шинэлэг болжээ.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сувилахуйн бакалаврын мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь 1-10 ботьд багтсан нилээд том хэмжээний ажил болжээ. Хөтөлбөрийн агуулгад жил бүр орчин үетэйгээ нийцүүлэн 10-20% д шинэчлэл хийх журмын дагуу хэмжээг багасгаж хялбархан болгох арга хэмжээ авах нь зүйтэй.

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн хөтөлбөрүүдийг мэргэжлийн багш, баг хамт олон боловсруулж тэнхмийн эрхлэгч, сургалтын албаны даргаар хянуулан сургалтаа явуулдаг ажиллагаа тогтмолжсон байна.
- Ерөнхий суурь хичээл ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарал, мэргэжлийн суурь хичээл ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарал, мэргэшүүлэх хичээл ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарлын судалгааг суралцагч оюутнуудаас авч сувилахуйн мэргэжилтний эзэмшвэл зохих 10 цогц чадамж, Меллерийн гурвалжингийн 5 түвшинтэй харьцуулан гаргасан.
- Сувилахуйн бакалаврын ангийн оюутнууд Дорноговь, Өмнөговь, Дундговь Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн НЭ, БОЭТөвүүдтэй гурвалсан гэрээний дагуу үйлдвэрлэлийн дадлагыг хийж байгаа нь суралцагчид мэргэжлийн ур чадвараа бататган сайжруулах бүрэн боломжтой эмнэлгийн байгууллагуудыг сонгосон.
- Ерөнхий, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн уялдаа холбоог дамжаа тус бүрт хэдэн кредитийн хичээл судлахыг гаргаж схемээр харуулсан байгаа нь сургалтын үйл ажиллагааны жишигт бүрэн нийцсэн.
- Суралцагчийн цагийн ачаалал гол төлөв өдөрт 8 цаг, 7 хоногт 40 цагаас хэтрэхгүй байгаа нь оюутны бие даан сурч, хөгжих боломжийг бүрэн хангасан.

Онцлог зүйл:

- 2022 оноос нэгж хичээлийн хөтөлбөр тус бүрийг сургалтын хөтөлбөр хариуцсан арга зүйч хянаж, багш бүрийн боловсруулсан хөтөлбөрт зонхилон тохиолдож буй 9 алдаа дутагдлыг илрүүлэн, сайжруулсан байгаа нь сайшаалтай.

Дүгнэлт: Хөтөлбөрийг зохих дүрэм журмын дагуу шинэчлэн боловсруулж, БСШУЯ-ны сайдын А/174 тоот тушаалын дагуу ерөнхий суурь хичээл 30% хүртэл, мэргэжлийн суурь хичээл 25% иас ихгүй, мэргэшүүлэх хичээл 45% иас доошгүй байна гэсэн чухал заалттай тохирч байхаас гадна үүнтэй уялдаатай хичээл хоорондын залгамж холбоо нь хоорондоо тохирч байгаа нь хангалттай сайн байна.

Үнэлгээ

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагсдад цөөн тохиолдолд 1-8 хоногийн хичээлгүй өдөртэй байгаа үед сургалт-хүмүүжлийн ажил, нийгэмд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх боломжоор хангах, асрамжийн буюу хүүхдийн байгууллагад туслах г.м ажил зохион байгуулахыг санал болгож байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтыг оюутан төвтэй тэдний оролцоог дэмжин чиглүүлж хичээлийг лекц, дадлага, семинар, бие даалт, онлайн сургалтын аргуудаас явуулж байгааг баримт нотолгоо харуулж байна. Багшийн хөгжлийг дэмжсэн 1-6 модуль сургалт ж-нь анагаах ухааны боловсрол судлал, сургалтын арга зүй, үнэлгээ, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй г.м сургалтад багш нар ээлж дараатай суралцан сурган заах арга зүйг сайжруулсан байна. Сувилахуйн мэргэжлийн багш нарын сурган заах арга зүйн талаар судалгааг сувилахуйн 1-4-р дамжааны 52 оюутнаас судалгаа авахад 86,6% нь хангалттай заасан гэж үнэлжээ.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Сувилахуйн мэргэжлийн багш нар 2021-2022 онд сургалтын Spices загварын арга, асуудалд суурилсан арга, чадамжид суурилсан арга г.м долоон аргыг сургалтандаа ашиглаж байсан бол 2022-2023 онд сурган заах аргаа сайжруулж 8 аргыг шинээр эзэмшиж хичээлдээ ашиглаж байна.

Дүгнэлт: Сургалтыг оюутан төвтэй тэдний оролцоог дэмжин чиглүүлсэн, мэргэжлийн багш нар сурган заах арга зүйн шинэлэг олон аргуудаас суралцаж хичээлдээ ашиглан үр дүнд хүрсэн нь харагдаж байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн үнэлгээг зохих тушаал, журмын дагуу суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж байгааг нотлох баримтууд харуулж байна. Багш бүр хөтөлбөрийн дагуу оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж дүнг сургуулийн удирдлага мэдээллийн системд шивж оруулан, оюутан бүр өөрийн ID кодоор нэвтрэн сурлагын дүн амжилт, чанараа харах боломжтой (www.student-web.xcloud.mn). Зөвшөөрөл авч нэг оюутны хичээлийн дүн, багшийн хичээлийн файлтай танилцав.

Онцлог зүйл:

- Анагаахын мэргэжил эзэмших гэж суралцагчийн мэдлэг, ур чадвар, цогц чадамжийг үнэлэх нь өвөрмөц онцлогтой. Иймд тус сургууль нь оюутны мэдлэгийг үнэлэх

шалгалтыг аман шалгалт, эссе бичих, олон хувилбарт сорил, компьютерт суурилсан сорил, кейсд суурилсан сорил, ур чадвар үнэлэх шалгалтыг өөртөөчилсөн шалгалт, гардан шалгалт, цогц чадамжийг үнэлэх шалгалтыг 360 хэмийн үнэлгээ (зөвхөн хандлага харилцааг үнэлнэ) гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ зэргээр шалгалтын төрлийг олшруулан явуулсан нь шинэлэг сайн ажил болжээ.

Дүгнэлт: Суралцагчдыг үнэлэх олон аргыг ашиглан, 2500 гаруй сорилыг боловсруулан хэрэглэж тэдгээр сорилын тохиромжтой харьцаа нь 85% байгаа нь өндөр үзүүлэлттэй байна. 2018-2022 оны хичээлийн жилд төгссөн 72 оюутны голч дүн, сурлагын амжилт болон сурлагын чанар жил бүр өссөн үзүүлэлттэй, сүүлийн 5 жилд Сувилах эрхийн зөвшөөрөл авах шалгалтанд 90%-иас дээш амжилт үзүүлсэн зэрэг нь сургалтын үйл ажиллагаа хангалттай сайн байгааг харуулж байна.

Үнэлгээ

- Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургууль нь анх 1962 онд байгуулагдсан. 400 оюутан хичээллэх 1264 м² хичээлийн төв байр буюу “Хичээлийн 1 дүгээр байр”, 200 оюутан хичээллэх 1232 м² талбайтай “Хичээлийн 2 дугаар байр”, 1950 м² Мандах-Наран оюутан түшиц эмнэлэгтэй, 260 оюутан амьдрах оюутны дотуур байртай, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум дахь “Аварга тосон” амралтын газартайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд түүхт 60 жилийн ойг тэмдэглэсэн.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн нэг оюутанд ноогдох талбайн хэмжээ: хичээлийн төв байр 2.53 м² хичээлийн 2 дугаар байр 7.79 м², Мандах Наран эмнэлэг 3.6 м² номын сан 1.56 м² тус тус талбай ноогдож байгаа нь сургуулийн барилга байгууламж, хичээлийн анги танхим, оюутны байр, лаборатори 1 оюутанд ноогдох стандарт хэмжээг хангасан.
- Мандах Наран түшиц эмнэлэг нь 14 эмч сувилагч багш нар үзлэгийн 11 кабинетад амбулаториор 240 хүнд, төсөл хөтөлбөрөөр 146 хүнд, идэвхтэй үзлэгээр (сайн үйлсийн аян) 75 хүнд, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгээр орон нутагт үйл ажиллагаа явуулдаг

4 байгууллагын 480 хүнд эрүүл мэндийн тусламж үзүүлж, зөвлөгөө өгсөн. 30,6 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх оноос 6.8 хувиар нэмэгдсэн.

- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрийн дадлагын Сувилахуйн эмнэлзүйн ур чадварын 7 төвтэй. Сургуулийн 1 дүгээр байранд сувилахуйн (87.3м²), мэс заслын (36.15м²), яаралтайн (70.3м²) хичээлийн ур чадварын 3 өрөө бүхий, сургуулийн 2 дугаар байранд эхийн сувилахуй, хүүхдийн сувилахуй (54.8 м²), дотрын (27.5м²) сувилахуйн 3 өрөө бүхий ур чадварын төвтэй.
- Удирдлагын мэдээллийн ДБУМС-HEMIS програмаар багш, оюутнуудын шаардлагатай мэдээллээр хангаж ажилдаг. (Зураг 3.1.1)
- Вебинар хичээл орох classroom, googlemet, zoom, E-Learning ашигладаг программтай, сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжтой, цахим номын сантай, онлайн хурал, цахим хичээл явуулах тоног төхөөрөмжөөр тоноглон Мэдээлэл технологийн кабинет 18 компьютертай.
- Сувилахуйн ур чадварын өрөө, лабораторид, молекул биологийн лаборатори, эм судлалын кабинет болон бусад дадлагын өрөөнүүдэд оюутны мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны заавартай. Аюулгүй ажиллагааны зааврыг оюутнуудад танилцуулж гарын үсэг авч баталгаажуулдаг.
- Оюутны дотуур байртай. 230-240 оюутан авах хүчин чадалтай. 1 багш, харуул хамгаалалтын ажилтан 4, үйлчлэгч 1 гэсэн орон тоотойгоор ЗХШҮ-ны албанд харьяалагдаж ажиллаж байна. Энэ хичээлийн жилд 234 оюутан бүртгэгдэж хамтын гэрээ хийж орсон. Оюутан хүлээж авсан өдрөөс 7 хоногийн дараа нийт оюутнуудад хурал хийж байрны дотоод дүрэм журмыг танилцуулдаг. Дотуур байрны зөвлөлийн дарга 1, гишүүд 6 оюутан байхаар сонгодог. Зөвлөлийн дарга, гишүүд байрны төлбөрөөс 40-50% хөнгөлдөг. 1 дүгээр курсийн оюутнуудад байрны төлбөрийн 10%-ийн хөнгөлөлт үзүүлдэг. Дотуур байрны давхар бүрт хоол хийх нэгдсэн гал тогоотой. Хувцас угаах угаалгын хэсэгтэй. Усанд орох халуун усны хэсэгтэй.

Онцлог зүйл:

- “Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилгоо хөтөлбөр”-ийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн XIII дугаар 13/01 тогтоолоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн цогцолборын 25 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын төсвийг 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад суулгасан.
- Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн хажууд сургуулийн 2 дугаар байр байршиж оюутнууд дадлага хийх боломж их байдаг.
- Мандах наран түшиц эмнэлэгтэй. Өөрийн эмнэлэгтэй тул оюутнууд дадлага хийж ур чадвараа сайжруулдаг.
- Сургууль, оюутны байранд үнэгүй WiFi-тай.
- Эрүүл шүд-Эрүүл ирээдүй аяны хүрээнд ариун цэврийн өрөөнд шүдний ОО тогтмол байршуулсан. Дуусахаар нөхөлт хийгддэг.

- Цалинтай-Оюутан хөтөлбөрийн хүрээнд халуун усны үйл ажиллагааг тодорхой хэмжээний төлбөр тогтоон 1 оюутад хариуцуулан ажиллуулж орлогын 40%-аар цалинжуулдаг. Канон, принтер, маникюр ажиллуулж нөхцөл боломжоор хангаж өгсөн байна.
- Гэр бүл болсон оюутнуудыг тусгай 2 хүний өрөөнд амьдруулдаг.

Дүгнэлт: Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн материаллаг нөөц, нэг бүрийн хэрэгсэл, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, виртуал, дижитал видео, аудио эх үүсвэр, сургалт судалгааны лицензтэй программаар бүрэн хангагдсан байна.
- Сувилахуйн бакалаврын сургалтын хүрээнд Сувилахуйн ур чадварын төвд 90 нэр төрлийн 213 ширхэг хэрэглэгдэхүүнийг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Жил бүр сургалтын хэрэглэгдэхүүнийг захиалж худалдан авалт, хангалт хийгддэг. 2019-2023 онуудад нийт 141 нэр төрлийн 3891 ширхэг 6130735 төгрөгөөр худалдан авалт хийсэн. Ихэвчлэн түгээмэл үлдлийн гардан ажилбаруудын хэрэгслүүдийн хангалт хийдэг.
- 2019- 2023 онд Сувилахуйн сургалтын хэрэглэгдэхүүнд 141 төрлийн 3891 ширхэг 6139735 төгрөгийн хэрэглэгдэхүүн худалдан авсан.
- Сувилахуйн хөтөлбөрт зарцуулагдах зардлын тооцоотой. 2019-2023 онуудад 882270000 төг төсвийг зарцуулсан. Жилд дунджаар 165 сая төгрөгийн зарцуулалттай. Нэг оюутанд дунджаар 3 сая төгрөгний зардал гардаг тооцоотой.
- Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаатай (гарын авлага, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, виртуал, дижитал видео, аудио контент тоогоор)
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/19 тушаалаар “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”, “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журамтай”
- 2020 онд 7 хөтөлбөрийн хүрээнд 21 ангид “Цахим хичээл” нэртэй групп хаяг нээж хичээлүүдээ байршуулсан. Сувилахуйн 100 цахим сорилын сантай. Цахим 1170 үүнээс 359 монгол, 649 англи, 162 орос номтой. Moodle системд 5 хөтөлбөрөөр суралцагчдын 58 бүлгийг үүсгэн цахим сургалтын тасралтгүй байдлыг хангасан. Цахим хичээлийн 5 жилийн судалгаатай.

Онцлог зүйл:

- Лабораторийн кабинетыг тохижуулж микроскопийн тоог нэмэгдүүлсэн.
- Сургалтын ангиудын цонхны хөшгийг тухайн хичээлийн хэрэглэгдэхүүний танилцуулга зургийг суулгаж хэвлүүлснээр оюутны мэдлэгийг дээшлүүлсэн.
- Микробиологийн хичээлийн үзүүлэнг оюутнууд өөрсдөө хийж хичээлийн явцдаа ашигладаг.
- Сувилахуй, эх барихуйн ангийн 81 оюутнаас санал асуулга авч судалгаанд оролцогчдын 4.9% нь хичээлд хэрэглэсэн техник хэрэгсэл хангалтгүй ялангуяа хүчилтөрөгчийн аппарат, салиа соруулах аппарат байхгүй гэж гарсан үр дүнг сайжруулж хүчилтөрөгч өтгөрүүлэгч, салиа соруулах аппарат, нярайн дулаалгатай ширээг ашиглах боломжтой болгосон байна.

Дүгнэлт: Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 247 м² талбайтай, 116 оюутны суудалтай номын сантай. Нэг оюутанд ноогдох номын сангийн талбайн хэмжээ 3.39м². АШУҮИС-ийн эрдэмтэн, судлаачдын 160 гаруй эрдмийн бүтээлийг, уншигчдын эрэлт хэрэгцээтэй 129 номыг цахим хэлбэрт шилжүүлж КОНА программд шилжүүлсэн.
- Номын санг Эрдэм шинжилгээ мэдээлэл технологийн алба хариуцдаг. Алба нь 6 хүний бүрэлдэхүүнтэй үүнээс 3 номын санчтай. Номын сангийн эрхлэгч, гэрээр ном олгох номын санч. Уншлагын танхимын хоёр номын санчтай.
- Сувилахуйн хөтөлбөрийн хүрээнд нийт 305 нэр төрлийн 2079 ширхэг номоос 119 нэр төрлийн 140 ширхэг ном нь үндсэн сурах бичиг, 113 нэр төрлийн 592 гарын авлага, 73 нэр төрлийн 445 ширхэг сэтгүүл, мөн 459 нэр төрлийн цахим номоос 170 нэр төрлийн монгол цахим ном ашиглагдаж байна.
- Цахим номын санд нь 2023 оны байдлаар нийт 6484 бүтээл байна. Үүнд: цахим ном 1358, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл 4075, магистр, доктор, бакалаврын дипломын товч хураангуй 899, эрдмийн чуулган 103, эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл 25, хурлын эмхэтгэл 24 цахим хэлбэрээр уншуулж байна. Номын санд бүртгэлтэй багш, ажилтан, оюутнууд <http://library.mnnums.edu.mn> хаягаар цахим кодоороо нэвтрэн уншиж байна.

- Сувилахуйн хөтөлбөрөөр суралцагч нарт зориулсан сувилахуйн гарын авлагын судалгаатай. Сүүлийн 5 жилийн хугацаанд 309 ном сувилахуйн хөтөлбөрийн хүрээнд хангагдсан.
- Сургалт, судалгааны лиценз эзэмшсэн 9 программтай. Номын сан нь 9 компьютер бүхий WI-FI төхөөрөмжтэй интернэтийн танхимаар үйлчилдэг. Олон улсын нээлттэй программыг ашиглаж онлайн мэдээллийн сангийн ашиглалт жил бүр өсөж байна.
- Цахим ном уншилтын мэдээ: 2020 онд GNB 63 оюутан, 2021 онд GNB 160 оюутан, 2022 онд GNB 34 оюутан, 2023 онд GND 85 оюутан
- Сувилахуйн оюутнуудын ном уншилтын мэдээ: 2021-2022 хичээлийн жилд уншсан номын тоо 687, 2022-2023 онд 650 удаа ном уншсан байна.

Онцлог зүйл:

- Долоо хоногийн 6 өдөр ажилладаг өдөрт 12 цагаар ажилдаг, хагас сайнд 7 цагаар ажилладаг.
- Оюутан номын санч аян зохион байгуулж оюутнуудыг номтой нөхөрлүүлэх, номын сангийн үйл ажиллагааг ойлгох зорилгоор зохион байгуулдаг.
- Номын сангийн дээд давхарт багаараа ажиллах буланг тохижуулсан.

Дүгнэлт: Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Номын санчдыг орон тоогоор нь ажиллуулах, мэргэшүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах.
- Номын санг зориулалтын байртай болгох.
- Техник тоног төхөөрөмжийг сайжруулах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 3. Нотлох баримтууд:



Зураг Сувилахуйн ур чадварын төв, мэдээлэл технологийн кабинет



Зураг. Оюутны дотуур байр




Зураг Эрүүл шүд-Эрүүл ирээдүй аян



Зураг.Лабораторийн микроскоп, анги танхимын хөшиг



Зураг Оюутнуудын хийсэн микробиологийн хичээлийн үзүүлэн



Зураг. Номын сан, багаар ажиллах булан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2023 оны 01 сарын 13-ны өдрийн А/13 тоот тушаалаар одоогийн бүтэц орон тоо батлагдсан: зөвлөл 2, хороо 2, алба 6, тэнхим 4, номын сан 1, сургуулийн эмнэлэг 1, сувилал 1, оюутны байр 1
- АШУҮИС-ийн захирлын 2023 оны 03 сарын 10-ны өдрийн А/59 тоот тушаалаар шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, үр дүнг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх эрхтэй, орон тооны бус, байнгын ажиллагаатай эрдэмтдийн зөвлөлтэй болсон
- АШУҮИС-ийн захирлын 2022 оны 03 сарын 15-ны өдрийн А/58 тоот тушаалаар батлагдсан “Эрдэмтдийн зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг баримталж ажилладаг.
- АУС-ийн захирлын 2022 оны 04 сарын 14- ний өдрийн А/29 тоот тушаалаар шинэчлэн баталсан Хөтөлбөрийн дэд хороо төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангадаг.
- Жил бүр багш нарын цагийн ачааллыг тооцон, шаардлагатай орон тоог нийтэд зарлан, багш нарыг сонгон шалгаруулж авдаг.
- Удирдлагын түвшинд ажиллаж байгаа эмч багш нар өөрсдийн мэргэшсэн чиглэлээр хичээл зааж эхэлснээр эмнэл зүйн багш нарын ачаалал буурч, багшийн хүрэлцээг нэмэгдүүлсэн.
- Сургалт, үйл ажиллагаанд баримталдаг дүрэм, журмыг эмхэтгэн багш, оюутнууд, олон нийтийн хүртээл болгож эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.
- Багш бүр урт болон богино хугацааны төлөвлөгөө гарган, жилд 2 удаа гүйцэтгэлийн тайлан бичиж, мэргэжил, эрдэм шинжилгээ, сургалт гэсэн 3 чиглэлээр үнэлгээ хийлгэж, ажлаа дүгнүүлдэг.
- Байгууллагын дотоод аудитын баг төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хөтөлбөрийн хэрэгжилт, шинэчлэл, сайжруулалтад хийдэг.
- АУС-ийн хэрэглэгчдийн шаардлагыг хангахгүй бүтээгдэхүүн үйлчилгээ, багшийн ёс зүй, болон бусад асуудлаар ирсэн гомдлыг сард 1 удаа хайрцгаар хүлээн авч эзэн бие холбогдогчтой, тодорхой баримттай ирсэн материалуудыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн хариу өгөхөөс гадна, гомдлын дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг /сүүлийн 5 жилд багш нарын заах аргатай холбоотой 6, үйлчилгээний ажилтантай

холбоотой 1, оюутны бүртгэл мэдээлэлтэй холбоотой 56, нийт 63 санал, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн/

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн хэрэгжилт, шинэчлэлд байнга хяналт тавьж, алдааг засаж, өөрчлөх зөвлөгөөгөөр хангадаг.
- Сургалт, үйл ажиллагаанд баримталдаг дүрэм, журмыг эмхэтгэн багш, оюутнууд, олон нийтэд хүртээлтэй болгосон.
- Багшийн нөөцийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахад дотоод нөөц бололцоог ашигласан.
- Орон тооны бус эрдмийн зөвлөлтэй болсон.

Дүгнэлт: Хөтөлбөрийн сайжруулалт, шинэчлэлд байнгын хяналт тавьж ажилладаг, багш нарын бүтээл, тэдний эрдэм шинжилгээ судалгааны ажилд зөвлөж, чиглүүлэх эрдмийн зөвлөлтэй болсон нь багш нарыг судалгааны ажилд сонирхолтой болгох, бүтээлүүдийг чанаржуулах, эрдмийн зэрэг хамгаалахад их дөхөм болно гэж үзэж байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс багшлах чадвартай, зөв төлөвшсөн хүүхдийг бэлтгэх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд 4 улсын 10 их дээд сургууль, олон нийтийн байгууллага, олон улсын 5 байгууллага, дотоодын их дээд сургуулиуд, нутгийн удирдлагын болон хувийн хэвшлийн байгууллагатай амжилттай хамтран ажиллаж байна.
- Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар "АНАГААХЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР"-ийг батлуулсан.
- Япон улсын Китасато сувилахуйн сургуультай хамтын гэрээний шинэчлэлийг хийж гэрээг сунгасан.
- Олон улсын байгууллагатай хамтран 9 сургалт, эрдэм шинжилгээний хурал, 7 удаа цахим сургалт хийсэн.

- БНХАУ, Япон, Энэтхэг, Германы сувилахуйн сургуультай хийсэн гэрээний дагуу багш, оюутныг солилцох, богино хугацааны сургалтанд суралцуулдаг / нийт 19 багш, оюутан хамрагдсан/
- АШУҮИС-ийн бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхим, эрдэм шинжилгээний лабораториудад багш нарыг ажиллуулдаг /нийт 14 багш хуваарийн дагуу харьяалагдах мэргэжлийн тэнхимдээ 2- 14 хоногийн хугацаатай ажилласан/
- АШУҮИС-ийн “Захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг”-г 3 багш авсан.
- Оюутан түшиц эмнэлэг, Аварга тосон амралтын газар, бүсийн аймгуудын ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ-үүдэд багш, оюутнууд ажиллаж, дадлага хийдэг.
- Цар тахлын үед Дорноговь аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Хамтдаа давья” аяны хүрээнд сургуулийн 30 багш, 54 оюутан “Call center” мэдээллийн төвд 1 сарын хугацаатай ард иргэдэд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.
- Төгсөгчдөд мэргэшил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, багц цагийн сургалтыг хийдэг / нийт 1874 хүн хамрагдсан/

Онцлог зүйл:

- Гадаад хамтын ажиллагаа сайн.
- Төгсөгчидтэй эргэх холбоо сайн.
- Аймгийн удирдлагуудтай хамтран ажилладаг, дэмжлэг сайтай.

Дүгнэлт: Гадаад, дотоодын хамтын ажиллагаа сайн, мэргэжилтнийг бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх сургалтуудыг хангалттай зохион байгуулдаг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төслийн үр дүнг тооцож, дүгнэлт хийдэг, төслийн тайланг бичиж хүлээлгэж өгдөг болох.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн төсөв 12 их үүсвэртэй, сургалтын төлбөр, оюутны байр, дахин болон хичээл нөхөлт, бусад орлого, хүүгийн орлого нийт төсвийн 97.6%-ийг бүрдүүлдэг.
- Сүүлийн таван жилийн дунджаар нийт зардал 1.5 тэрбум төгрөг, үүнээс сувилахуйн хөтөлбөрт зарцуулагдаж буй зардал 165.6 сая төгрөг буюу 11.4 %, сувилахуйн хөтөлбөрт суралцаж буй нэг оюутанд ноогдох зардал 3.03 сая төгрөг байна.

- Сувилагч мэргэжлээр суралцаж буй 55 оюутны 51 нь буюу 92.7 хувь улсын тэтгэлэг авч байна.
- Багшийн хөгжилд зарцуулсан зардалын тооцоо: эрдэм шинжилгээний хуралд 2019-2023 онд 49.536.920, докторантурын сургалтын төлбөрт 22.062.400, резидентийн сургалтанд 1.830.400, мэргэжил дээшлүүлэхэд 7.318.933, багш солилцоонд 24.135.721 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Онцлог зүйл:

- Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 70-р тогтоолоор төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь, суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд 100 хувь төрөөс хариуцдаг.
- Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ганц их сургуулийн хувьд орон нутгийн дэмжлэгийг байнга авдаг /2020 онд оюутны дотуур байрны бүрэн засварт 232.324.537 төгрөгийн дэмжлэг авсан/

Дүгнэлт: Санхүүгийн хувьд өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг хангалттай сайн гаргаж, аудитын шалгалтаар ямар нэгэн алдаа дутагдалгүй шалгагдсан байна. Багшийн хөгжилд тусламж, дэмжлэг хангалттай үзүүлдэг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутанд олгож байгаа тэтгэлгийг төрлөөр ангилан гаргах
- Хөтөлбөрийн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулах төсвийг тодорхой болгох

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн сурталчилгаа хийдэг хэлбэрүүд:

- Багш шавийн уулзалтыг жил бүр зохион байгуулдаг: 2022 онд зүүн бүсийн аймгууд, Улаанбаатарт, Дорноговьд 3 удаан зохион байгуулсан .
- Төгсөгчдийн чуулган тогтмол зохион байгуулдаг.
- Контент болон зар бэлтгэн олон нийтийн сүлжээ, орон нутгийн телевиз, фм радиогоор цацуулдаг.

- Орон нутгаас зохион байгуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын өдөрлөгт оролцдог.
- Сум орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж, шаардлагатай мэргэжилтнүүдийг захиалгаар бэлтгэдэг.
- Элсэлтийн үйл ажиллагааг цахимаар бүртгэдэг болсон.
- “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг жил бүр зохион байгуулдаг
- ЕБС-ын сурагчдад зориулан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, өдөрлөг, уулзалтыг жил бүр зохион байгуулдаг.

Онцлог зүйл:

- Төгсөгчдийн холбоотой нягт хамтран ажилладаг.

Дүгнэлт: Хөтөлбөрийн сурталчилгааг олон хэлбэрээр хангалттай зохион байгуулдаг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын тухай хуулийн 42.1, 42.2, 42.9-д заасны дагуу, чанарын хяналтын ISO 9001:2015 шаардлага, Компьютерын программ хангамжийн MNS 5323:2009 стандартыг хангасан вэб сайттай.
- Олон нийтэд зориулсан: сургуулийн албан ёсны 12 цахим хаягтай, цахим сэтгүүл 1, брошур 3, шторк 4, реел 3

Онцлог зүйл:

- Чанарын хяналтын ISO 9001:2015- стандарт нэвтрүүлсэн.

Дүгнэлт: Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, элсэлттэй холбогдолтой мэдээлэл, цаг үеийн мэдээллийг хөдөлмөрчдөд олон сувгаар хүргэж байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн шаардлагатай зохицуулалтыг мөрдлөг болгодог. Монгол улсын засгийн газрын тогтоол, Дээд боловсролын тухай хууль, БШУС-ын тушаалууд, Боловсролын ерөнхий газрын даргын албан тоотууд, АШУҮИС-ийн УЗ-ийн тогтоолууд, АШУҮИС-ийн захирлын тушаалын 2023 оны 04 сарын 26-ны А/109 тоот тушаал “АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам батлах тухай” журмыг мөрдлөг болгодог.
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр элссэн оюутны тоон судалгаатай. Сүүлийн 5 жилийн байдлаар нийт 823 оюутан элссэн суралцсаны 110 буюу 13.3 хувь нь тус хөтөлбөрийн элсэгчид байна. Мөн хяналтын тоонд нийт 510 батлагдсан үүнээс 110 буюу 21.5 хувь нь элссэн.
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааны судалгаатай. 2019-2022 оны хичээлийн жилүүдэд хяналтын жил бүр 90 байсан бол, 2022-2023 оны хичээлийн жил, 2023-2024 оны хичээлийн жилүүдэд хяналтын тоо 150 болсон байна. Харин элсэгчдийн хувь харьцангуй бага байна. Сүүлийн 5 жилийн байдлаар Сувилахуйн бакалаврын ангид 79 оюутан элссэн ба одоогийн байдлаар нийт 68 оюутан суралцаж байна. ЭЕШ-ийн дундаж оноо (2020-504/2023-441)
- АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь АУС-ийн таван жилийн дунджаар нийт орлого 1,6 тэрбум төгрөг бөгөөд үүнээс сургалтын төлбөрийн орлого 1 тэрбум төгрөг буюу 62.5 хувийг бүрдүүлдэг. Сувилахуйн хөтөлбөрийн сургалтын төлбөрийн орлого нь 179.1 сая төгрөг бөгөөд 12.4 хувийг бүрдүүлдэг.
- Сүүлийн таван жилийн дунджаар нийт зардал 1.5 тэрбум төгрөг бөгөөд үүнээс сувилахуйн хөтөлбөрт зарцуулагдаж буй зардал 165.6 сая төгрөг буюу 11.4 хувийг эзэлдэг. Сувилахуйн хөтөлбөрт суралцаж буй нэг оюутанд ноогдох зардал 3.03 сая төгрөг байна.

Онцлог зүйл:

- Шинээр элсэгчдэд зориулсан “Удиртгал” хичээлийг цахим, танхимаар 7 хоногийн хугацаанд зохион байгуулдаг. “Оюутны гарын авлага”-тай. Энэхүү гарын авлагад сургуулийн хэмжээнд мөрддөг төгсөлтийн өмнөх сургалтыг зохицуулах журам, элсэгч, төгсөгчдөд тавигдах шаардлага, сургалтын үнэлгээ, хичээл сонгох, дадлага хийх журам, ёс зүйн хэм хэмжээ зэрэг суралцах хугацаандаа даган биелүүлбэл зохих мэдээллийг багтаасан.
- Элсэлтийн ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 8 аймагт сургууль сурталчлах цахим болон бусад төрлийн 14 арга хэмжээг зохион байгуулан, оюутнуудын дунд сургуулиа сурталчлах контентын уралдааныг зохион байгуулж 2.2 сая төгрөгийн урамшуулал олгосон.

- Бүсийн 7 аймгийн “Төгсөгчдийн холбоо”-той хамтран 4 арга хэмжээ, аймаг бүрд ЕБС-ын 500 гаруй сурагчдыг хамруулсан.

Дүгнэлт: АШУҮИС-ийн захирлын тушаалын 2023 оны 04 сарын 26-ны А/109 тоот тушаал “АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам батлах тухай” журам болон бусад хууль эрх зүйн хүрээнд элсэгчдийг сонгон шалгаруулдаг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ажил олгогчтой уулзалт хийхэд бүсийн эрүүл мэндийн байгууллагуудад сувилагчийн дутагдал хэвээрээ байгаа тул элсэгчдийн тоог нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургуулийн сурталчилгаа, мэргэжлийн онцлог, төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаар цахимаар болон бодит сурталчилгааг нэмэгдүүлэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн хэмжээнд жил бүр сургууль, багш, оюутантай холбоотой бүхий л үйл ажиллагааг тусгасан сургалт хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй, хэрэгжилтэд хяналт тавьдаг.
- Оюутны дотуур байртай. Сувилахуйн хөтөлбөрийн суралцагч 8.2% эзэлдэг. Оюутны сурч, амьдрах тав тухтай орчинг бүрдүүлсэн. “Оюутан түшиц” эмнэлэг нь оюутны урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулдаг. “Эрүүл оюутан-Эрүүл үр дүн” уриатай сарын аян зохион байгуулсан. “Намрын спарткад”, “Урлагийн бага наадам” зохион байгуулдаг. “Цагаан бүжиг” бүжгийн хамтлагтай. Суралцагчдад зориулан бие хүний хөгжил төлөвшил, хандлага, харилцаа, ёс зүй, эрүүл аж төрөх чиглэлүүдээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг, сургалт, аян, үйл ажиллагааг тогтмолжуулсан.
- Оюутнуудын судалгаа, шинжилгээний ажлыг чиглүүлэх, дэмжин туслах, идэвхжүүлэх, урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг. Эрдэм шинжилгээний ажил удирдаж байгаа багш нарыг урамшуулан дэмждэг. Эрдэм шинжилгээний хурлын зардлын судалгааг 5 жилээр тооцож гаргасан. Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн судалгаатай.
- Сүүлийн 5 жилийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаатай. Сувилахуйн бакалаврын төгсөгчдийн дунджаар 82 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Цагийн ажил хийдэг оюутны тоон мэдээллийн сүүлийн 5 жилийн судалгаатай. 2019-2023 онуудад нийт 23 оюутан цагийн ажил хийсэн.

Онцлог зүйл:

- Шинээр элсэн орсон оюутнуудад зориулсан “Оюутны гарын авлага”-тай. Агуулгад: АШУҮИС-ийн оюутны тангараг, Сургуулийн танилцуулга, АШУҮИС-ийн суурь сургалтын хөтөлбөрийн зохицуулах журам, төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, суралцагчийн үнэлэх журам, сургалтын технологи, сонгон сургалцах, дадлагын, багц цаг дүйцүүлэн тооцох журмууд, өвөл, зуны сургалтын ерөнхий удирдамж, номын сан, цахим програмууд болон бусад оюутанд шаардлагатай мэдээллүүдийг багтаасан байна.
- 2023-2024 оны хичээлийн шинэ жилд шинээр элссэн оюутнуудад зориулсан “Орон нутагтай танилцах” аяллыг Оюутны нийгэмлэг, Сургалтын албатай хамтран зохион байгуулсан.

Дүгнэлт: Оюутанд зориулан жил бүр сургуулийн хэмжээнд сургалт, хүмүүжлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан захирлын зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлдэг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны нийгэмлэг нь 1 тэргүүн, анги хэсгийн дарга нараас бүрддэг. Оюутны нийгэмлэг нь урлаг, соёл хүмүүжлийн баг, эрдэм шинжилгээ технологийн баг, олон нийт хэвлэлийн баг, сонирхлын бүлгээс бүрдсэн 10 клубийн үйл ажиллагааг чиглүүлэн, дэмжин ажилладаг. Клубүүд нь үйл ажиллагаагаа улирал бүр тайлагнан дүгнүүлж багш, удирдлагуудын санал, шүүмжийг сонсон үйл ажиллагаагаа сайжруулан ажилладаг.
- Оюутнуудад суралцах хугацаандаа төсөл бичих, хэрэгжүүлэх ур чадварт сургах, тэдний бүтээлч санал, санаачилгыг сургуулийн зүгээс эрх зүйн зохицуулалтын хүрээнд дэмждэг.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран суралцагчдын сайн дурын ажлын бүртгэл, зохион байгуулалт, сайн дурын ажилтны үүрэг, хориглох зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих, сайн дурын ажлын явц, үр дүнг орон нутгийн Залуучуудын хөгжлийн төвийн саналыг үндэслэн үнэлдэг.
- Оюутан суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох “Орлоготой оюутан хөтөлбөр” хэрэгждэг.
- Оюутны бие даан ажиллах чадварыг сайжруулах зорилгоор 10 гаруй ур чадварын уралдаан тэмцээн, олимпиадыг зохион байгуулсан.
- Сургуулийн тэтгэлэг олгох журамтай. Шаардлага хангасан 51 оюутан тус бүр 500,000 төгрөгийн тэтгэлгийг сүүлийн 5 жилд олгосон. Дорноговь аймгийн ЗДТГ-аас шалгуур

хангасан оюутнуудад төлбөрийн 1 сая төгрөгийн тэтгэлэг олгодог. Монгол Улсын Засгийн Газрын 346 тоот тогтоолын дагуу хөдөө орон нутгийн 50% хөнгөлөлт, 70-р тогтоолоор сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын голч дүнгээс хамаарсан 70%, 100%-ийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдаж байна.

- “Эерэг Хандлага- Эрүүл оюутан” эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд оюутнуудын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулдаг. 2023 онд нийт 479 оюутан хамрагдах ёстой байснаас 442 оюутан хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэг 92 хувьтай байна.

Онцлог зүйл:

- Сувилахуйн оюутнуудын сургалтаас бусад үйл ажиллагаанд зориулж 2023 онд нийт 2,070,100 төг санхүүжилт зориулсан байна. Үүнд: Олимпиадын шагналын төсөв, ажил мэргэжлийн тэмцээний шагналын төсөв, мэс заслын сувилагчдын анхдугаар зөвлөгөөнд оролцсон оюутны замын зардал, спортын тэмцээний шагнал, буцалтгүй тусламж үзүүлдэг.
- Дорноговь аймгийн аварга шалгаруулах “ХИЙН ДАСГАЛЫН”-ын тэмцээнд Сувилахуйн бакалаврын 2-р дамжаа Гутгаар байр эзэлж амжилттай оролцсон.
- “САЙН ҮЙЛСИЙН АЯНЫ” хүрээнд гэрийн асаргаа шаардлагатай иргэдэд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн.
- “ЦЭВЭР ХАЛАД-МЭРГЭЖЛИЙН БАХАРХАЛ” аяны хүрээнд Сувилахуйн тэнхимийн оюутнууд Тэргүүн байр эзэлсэн.
- “САЙНШАНД- ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР 2023” арга хэмжээнд идэвхтэй оролцсон.
- “НЭГ ӨДӨР-НЭГ ДУРСАМЖ” сайн үйлсийн аяны “Ургах наран” цэцэрлэгт зохион байгуулсан.
- “УСНЫ ҮНЭ ЦЭНЭ” сэдвээр хүүхэд залууст ус хэрэглэх үнэ цэнийн тухай мэдээлэл хүргэж сургалт зохион байгуулсан.
- 2019 онд “Сувилахуйн ур чадварын улсын анхдугаар олимпиад”-ыг зохион байгуулж байсан.
- 2023 оны 04 сарын 17-ны өдөр “Сувилахуйн ур чадварын улсын хоёрдугаар олимпиад” зохион байгуулсан. Зардал 4 367 100 төг.
- Үндэсний хэмжээний “Сувилагч” реалити шоуны шилдэг 14 оролцогчийн 2 оролцогч нь тус сургуулийн төгсөгч нар байлаа. (Сувилагч Г.Шинэбаяр, Д.Нэргүй)
- “Оюутны хөгжил” хөтөлбөрийн хүрээнд “Үлгэрлэгч оюутан” дэд хөтөлбөр, “Хөдөлмөрч оюутан” дэд хөтөлбөр, “Эх оронч оюутан” дэд хөтөлбөр, “Эрүүл авьяаслаг оюутан” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- Цалинтай-Оюутан хөтөлбөрийн хүрээнд халуун усны үйл ажиллагааг тодорхой хэмжээний төлбөр тогтоон 1 оюутанд хариуцуулан ажиллуулж, орлогын 40%-аар цалинжуулдаг. Канон, принтер, маникюр ажиллуулж нөхцөл боломжоор хангаж өгсөн байна.
- Сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлснээр сүүлийн жил элсэлт нэмэгдсэн.

- Говийн болон зүүн бүсийн аймгуудын эрүүл мэндийн салбарын сувилагч мэргэжилтний хүний нөөцийн 85-95 хувийг хангаж байна.

Дүгнэлт: Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг боловч олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцож байгаа оюутнуудыг урамшуулах, мотивац өгөх үйл ажиллагааг өргөжүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний сүүлийн 5 жилийн судалгаатай. Гарсан жилийн чөлөө авсан шилжсэн оюутан 2019-2023 онуудад нийт 26 оюутан. Үүнээс сургуулиас чөлөөлөгдсөн оюутан 6.
- Жилийн чөлөөнөөс болон шилжиж ирсэн оюутны тоо 2019-2023 онуудад нийт 21 оюутан.
- Хөтөлбөр хооронд шилжин суралцах оюутан “Багц цаг дүйцүүлэх тооцох журам”-ын дагуу Сургалтын алба дүйцүүлэн тооцдог. Дүйцүүлэн тооцох шаардлага хангахгүй тохиолдолд хөтөлбөрийн багц цагийн зөрүүг заавал нөхөн суралцуулдаг. Суралцагчийн шилжилт хөдөлгөөний жилийн чөлөө болон сургуулиас гарах болсон шалтгааны судалгаатай.

Дүгнэлт: Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хотоос орон нутагруу суралцах урсгалыг нэмэгдүүлэх. Өөрийн сургуулийн онцлог давуу тал, орон нутгийн дэмжлэг, Засгийн газрын үзүүлдэг дэмжлэгийн талаар сурталчилгаа явуулах, маркетинг хийх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн оюутнуудын төгсөлтийн баримт бичгийн загварыг 2012 оны 1-р сарын 2-ны өдрийн 01 дугаартай БСШУЯ-ны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын 1-р хавсралтын дагуу хийж гүйцэтгэдэг.
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7-р бүлэг, АШУҮИС-ийн дүрмийн 4.8.1, 4.8.5 дахь заалт, захиргааны зөвлөлийн 2021 оны 01-р сарын 22-ны өдрийн 21/1 тоот хурлын шийдвэрийг үндэслэн зохион байгуулдаг.
- БШУЯ-ны дээд боловсрол удирдлага мэдээллийн системд төгсөгчдийн хувийн мэдээлэл болон дипломын мэдээллийг бүртгэн баталгаажуулж, улмаар “E-Mongolia” цахим нэгдсэн мэдээллийн санд бүртгэл үүсэн, төгсөгчдийн талаарх боловсролын мэдээллийн лавлагааг дотоод, гадаад хаанаас ч авах боломжтой.
- МУ Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх гадрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн төгсөгчдийн дээд боловсролын бичиг баримтыг PDF хэлбэрээр, блокчэйнээр баталгаажуулах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилийн байдлаар Сувилахуйн бакалаврын ангид 79 оюутан элссэн суралцсан ба одоогийн байдлаар нийт 68 оюутан суралцаж байна.

Дүгнэлт: Төгсөлтийн баримт бичгийн загварыг 2012 оны 1-р сарын 2-ны өдрийн 01 дугаартай БСШУЯ-ны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын 1-р хавсралтын дагуу хийж гүйцэтгэдэг.

Үнэлгээ:

- **Бүрэн хангасан**

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага, АШУҮИС-ийн дүрмийн 4.8, 4.8.6 дахь заалтууд, АШУҮИС-ийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний АШУҮИС-ийн захирлын 2016 оны А/118 тоот тушаалаар батлагдсан АШУҮИСийн “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”, АШУҮИС-ийн Захирлын зөвлөлийн 2014 оны 5-р сарын 18-ны өдрийн хурлаар баталсан “Багшийн алтан дүрэм”, салбар сургуулийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн 5.1, 5.2 дахь заалтуудыг мөрдөн багшийг сонгон шалгаруулдаг /2018-2022 оны хооронд сувилахуйн хөтөлбөрт хичээл заах 5 багшийг сонгон шалгаруулж авсан/
- Сувилахуйн бакалаврын хөтөлбөрт нийт 31 багш хичээл зааж байгаагын магистрын зэрэгтэй 26, АУ-ны доктор дэд профессор 1, АУ-ны доктор 1, спортын мастер 1, зэрэггүй 2 байгаа нь эрдмийн зэрэг цолтой багш нар 93,5%-г эзэлж байна .
- Багш нарыг эрдэмжүүлэхэд анхаарч байна /докторантурт суралцаж байгаа 11 багшийг хугацаанд нь төгсгөх асуудалд онцгой анхаарч бодлогоор дэмжин ажилласнаар 2024 он гэхэд эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 38,2% болно гэж төлөвлөж байна/
- Сувилахуйн хөтөлбөрт суралцагчдын тоо 2018 онд нэг багшид 1,2 оюутан ноогдож байсан бол 2021 онд 6, 2022 онд 8 болж өссөн.
- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/270 тоот тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага”, АШУҮИС-ийн Багшийн алтан дүрэм, “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг мөрдөн сургалт, судалгааны ажлын чанар, үр дүнг харгалзан багш нарыг порфессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн албан тушаалын зэрэглэлд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулдаг /2022 онд багшийн албан тушаалын зэрэглэлээр дэд профессор 1, АУ-ны доктор, ахлах багш 4, магистр 29, дадлагажигч багш 3/
- сүүлийн 5 жилд 17 багш мэргэжлийн зэрэг хамгаалж, зэргийн нэмэгдлийг сар бүр авсан.

Дүгнэлт: Багш нар мэргэжлийн зэрэг хамгаалах, докторантурт суралцах зэргээр өөрсдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн 2-р бүлгийн 6.1-д заасны дагуу 2019 онд “Багшийн хөгжлийн 116 хөтөлбөр” боловсруулж 2022 онд сайжруулан 5 бүлэг 36 заалт бүхий “Багшийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг АШУҮИС-ийн захирлаар батлуулан хэрэгжүүлж байна.
- 2021 онд “Багшийн хөгжлийн төв” байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангаж хурал, зөвлөгөөн цахим хичээл, сургалтуудыг явуулдаг.
- 2022 оноос “Багшийн хөгжил хариуцсан арга зүйч”-тэй болсон.
- Багшийн хөгжлийн төлөвлөгөөнд багшийг чадавхжуулах ажлуудыг тусгаж, багшийг хөгжүүлэх 11 төрлийн 435 сургалтад давхардсан тоогоор 4172 багш хамрагдаж, ажлын байран дээр хөгжих боломжтой болсон.
- Сувилахуйн хөтөлбөрийн 10 багш олон улсын багш солилцооны хөтөлбөрт хамрагдаж, 2 багш мэргэжил дээшлүүлж, 5 багш туршлага судлаж, 4 багш TOSEL (олон улсын зөвлөх зэрэг) зэрэг хүртсэн.
- Багшийн хөгжил дэд хөтөлбөрийн хүрээнд АШУҮИС-ийн “Багшийн хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан сургалтад багш нар сууж сурган заах арга зүй сайжирч сургалтын чанарт ахиц гарсан, Монгол-Япон эмнэлэгт дадлагажуулах “Багш солилцооны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн 9 багш хамрагдсан.
- Япон хэлний сургалтад 3 багш сууж, япон хэлний N5 түвшний мэдлэг эзэмшсэн сертификат авч, 1 багш Япон улсын Шизүока мужийн Сувилахуйн сургуульд оюутнуудын хамт зуны дадлага хийсэн, англи хэлний сургалтад бүх багш хамрагдсан.
- Сургалтад хамрагдсан багш нарт сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгодог /12 багшийн сургалтын 50%-ийн хөнгөлөлтөд 3.291.000₮ олгосон/
- 2022 оны байдлаар 22 багш буюу багш нарын 59.4% нь мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн.
- Багшийн хөгжилд зориулан сүүлийн 5 жилд 94,067,020 төгрөгийг зарцуулж, сувилахуйн хөтөлбөрийн 34 багш хамрагдсан.

Онцлог зүйл:

- Ажлын байран дээр хөгжих боломжоор хангасан.
- Багшийн хөгжилд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Дүгнэлт: Багш нарын заах арга зүй, ур чадвар, мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг тасралтгүйгээр, төлөвлөгөөтэй зохион байгуулдаг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд судалгааны арга зүйн чиглэлийн 29 сургалтад давхардсан тоогоор 489 багшийг хамруулсан, үүний 480 нь сувилахуйн хөтөлбөрийн багш нар байсан.
- “Чадварлаг оюутан-2019, 2021,2022” оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.
- 2018 онд “Сувилахуйн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг бие даан зохион байгуулсан.
- 2021, 2022 онуудад THE INTERNATIONAL MEDICAL SCIENCE CONFERENCE VI, VII хурлыг өөрийн сургууль дээр зохион байгуулсан
- Зүүн болон говийн бүсийн 7 аймгийн ЭМГ, НЭ-тэй хамтарсан эрдэм шинжилгээний хурлаар эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааны ур чадварыг сайжруулах, эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал, төгсөгчдийн ур чадвар, ажил олгогчдын эрэлт хэрэгцээ, сувилагч мэргэжилтний сургалтын хэрэгцээг тодорхойлох зэрэг асуудлыг авч хэлэлцсэн.
- 5 жилд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар нийт 57 өгүүлэл, 225 илтгэл хэлэлцүүлж эрдэм шинжилгээний бүтээлийн тоо өссөн.
- Сувилахуйн хөтөлбөрийн багш нар 2018-2022 оны хооронд олон улсын сэтгүүлд 3 өгүүлэл хэвлүүлсэн. Өмнөд Солонгос улсын IF өндөртэй The Korean review of Korean Studies сэтгүүлд “STUDYING THE PROFESSIONAL QUALIFICATION FRAMEWORK OF PUBLIC HEALTH” өгүүлэл хэвлүүлэхээр илгээсэн.
- Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар 2011-2022 оны байдлаар зохиогчийн эрх-5, шинэ бүтээлийн патент-4 байна.
- Нийт 23 төсөл хэрэгжүүлсний 2 оюутны төсөл, 2 суурь судалгааны, 19 нь орон нутаг, сургуулийн захиалгат төсөл байсан.
- 2019 оноос хойш 11 багш докторантурт суралцаж байна.
- Сүүлийн 5 жилд эрдэм шинжилгээний зардалд 188,290,000 төгрөг төсөвлөж эрдэм шинжилгээний хурал, сургалт зохион байгуулахад нийт 66,468,339 төгрөгийг зарцуулсан /“Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 6 багш судалгаа, докторын ажилдаа хөнгөлөлт авсан/

Онцлог зүйл:

- Олон төсөл хэрэгжүүлсэн.
- Эрдэм шинжилгээ, судалгаа, хурал зохион байгуулахад хангалттай төсөвтэй.
- Багш нарын бүтээлийн чанарыг сайжруулахад анхаарч байна.
- Багш нарын зэрэг ахиулахад төлөвлөгөөтэй ажилладаг.

Дүгнэлт: Багш нарыг чадавхжуулах, судалгаа шинжилгээний ажлыг санхүүгээр хангадаг, олон улсын байгууллагатай хамтран ажилладаг зэрэг сайн талтай.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төслийн үр дүнг тооцож, дүгнэж шаардлагатай салбарт нэвтрүүлж, хэрэгжүүлэх
- Сурагцагчдад судалгааны арга зүй заах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, АШУҮИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, АШУҮИС-ийн “Багшийн алтан дүрэм”-ийн хүрээнд гаргасан “Багшийн гүйцэтгэлийг үнэлэх журам”-аар зохицуулдаг.
- Зөвлөлийн үнэлгээ, оюутны үнэлгээ, тэнхимийн үнэлгээн дээр үндэслэн “багш”-ийн ажлыг 3 жил тутам, “ахлах багш”, “дэд профессор”-ийн ажлыг 4 жил тутам, “профессор”-ийн ажлыг 5 жил тутамд үнэлж багшлах эрхийг баталгаажуулдаг.
- Багш өөрийн үнэлгээний тайланг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээр бичиж жилд 2 удаа (V, XI сар) тайлагнадаг.
- Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар гүйцэтгэх жилийн оноо 1600, үүнээс сургалтаар гүйцэтгэх оноо 600-680, эрдэм шинжилгээний оноо 210-350, мэргэжлийн үйл ажиллагаа 210-350 онооны хооронд хэлбэлздэг.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг тэнхимийн эрхлэгч баталгаажуулна. Сургалтын алба, Сургуулийн эмнэлэг, Эрдэм шинжилгээний алба, тэнхимийн тайланд үндэслэн Хяналт шинжилгээ үнэлгээний алба багшийн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн үнэлгээг 12 бүлэг 83 үзүүлэлтээр үнэлж зохих зөвлөмжийг хүргүүлдэг.
- Жил бүрийн 11-р сард тэнхимийн хурлаар багш нарын өөрийн үнэлгээний тайланг нээлттэй хэлэлцүүлж багш багшаа үнэлэн тэнхимийн шилдэг багшийг шалгаруулна. Тэнхимийн тайланг захиргааны зөвлөлөөр танилцуулж, захиргаанаас томилсон баг хөндлөнгийн үнэлгээ хийж тухайн жилийн шилдэг багш, тэнхимийг шалгаруулдаг.
- Багшийн ажлын хавтас үндсэн хэсэг, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, бусад, хичээлийн файлын сан гэсэн 6 бүлэг 39 үзүүлэлттэй, жил бүр баяжуулдаг.

- Багшийн ажлын үнэлгээ 80-аас дээш бол сайн, 70-79 хангалттай, 69-өөс доош хангалтгүй гэж үнэлнэ. 2023 онд 15 багшаас 12 багш 80-аас дээш үнэлэгдэн “Сайн” авсан, 3 багш эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн.

Дүгнэлт: Багш өөрийн ажлаа үнэлж, дүгнэн тайлагнах нь хэвшсэн, удирдлагын үнэлгээ бодитой, шилдэг багш, тэнхимийг шалгаруулж урамшуулдаг нь идэвхижүүлэх хөшүүрэг болдог .

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн бүтэц орон тоо 2022 онд дахин шинэчлэгдэж, Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба нэртэй болж, дотоод хяналт, үнэлгээний мэргэжилтэнтэй болсон.
- Сувилахуйн хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хэрэгжүүлэгч анхдагч нэгж нь багш нар, хөтөлбөрийн дэд хорооны дарга- сургуулийн захирал,
- Хөтөлбөрийн дэд хороо БСШУЯны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, АШУҮИС-ийн захирлын 2014 оны А/76 тоот тушаалын дагуу Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хяналт тавьж ажилласан
- Чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO9001:2015 стандартыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр нэвтрүүлэн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлт, үнэлгээ, хөгжүүлэлтэд чанарын баталгаажуулалт хийдэг.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “ААН, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, АШУҮИС-ийн захирлын 2021 оны 09 сарын 08 өдрийн А/179 тоот тушаал “АШУҮИСийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журам” баримталдаг.
- Дотоод хяналт үнэлгээний ажилтан нь жил бүрийн 1-р сард салбар сургуулийн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, жилийн эцэст нэгдсэн тайлан, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний тайланг нэгтгэн АШУҮИС-ийн захирлын зөвлөлд танилцуулж үр дүнг хэлэлцүүлдэг.

- Багш нарын тухайн жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг тэнхимийн эрхлэгч жилд 2 удаа үнэлж, хичээлийн жилийн төгсгөлд хяналт үнэлгээний мэргэжилтэн хянаж ажлын биелэлтийг баталгаажуулдаг.
- Сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны талаар хэрэглэгчдээс ирсэн санал, гомдолд дүн шинжилгээ хийж, үр дүнг захирлын зөвлөлийн хурал, холбогдох алба, нэгж, багш, ажилтанд танилцуулан санал зөвлөмжийг хүргүүлдэг.
- Дотоод аудитын баг төлөвлөгөөний дагуу чанарын хяналт хийж, гарсан зөрчлийг дотоод аудитын багаар хэлэлцүүлэн засах арга хэмжээ авдаг.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарын баталгаажуулалтын хүрээнд суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр гаргаж, үр дүнг сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлдэг/ оюутны сэтгэл ханамж 2021-22 онд 74%, төгсөгчдийнх 88,8%/
- Жил бүр элсэлт, төгсөлт, бусад үйл ажиллагаанд аймгийн мэргэжлийн хяналтын газар, аймгийн аудитын газар, төрийн аудитаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг залруулан ажиллаж тайланг холбогдох газруудад хүргүүлдэг.
- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд төрийн аудитын шалгалтыг жил бүр хийлгэж, санхүүгийн зөрчилгүй гарсан.

Дүгнэлт: Чанарын дотоод болон хөндлөнгийн үнэлгээг төлөвлөгөөтэй, тогтмол хийдэг.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- 2023 оны 11 сарын судалгаагаар: 2018-22 онд сувилахуйн бакалаврын хөтөлбөрөөр 74 мэргэжилтэн төгссөн, 75.6% нь мэргэжлээр, 14.8% нь өөр мэргэжлээр, 5.4% нь мэргэжил дээшлүүлж байгаа, 4% нь өөр мэргэжлээр сурсан, 28.3% нь олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдсан.
- 2023 оны төгсөгчдийн мөшгөх судалгаагаар төгсөгчдийн 35.2% нь сум орон нутагт тогтвортой ажиллаж, амьдарч байна.
- Төгсөгчид өөрийн чадварыг 8 үзүүлэлтээр үнэлсэн байдал: бие даан ажиллах чадвар 4, багаар ажиллах чадвар 4, бичих чадвар 3.5, ярианы чадвар 4.5, интернет ашиглах чадвар 4, мэргэжлийн мэдлэг 4,5, мэргэжлийн ур чадвар 4.5, бизнес эрхлэх ур чадвар 3,5 гэж үнэлсэн. 2018-19 оны 22 төгсөгчийн дундаж үнэлгээ 3.75 байсан бол 2021-22 оны 10 төгсөгчийн үнэлгээ 4,1 байгаа нь сургалтын чанар жил ирэх тусам дээшилж байна гэж үзэх боломжтой.

- Зүүн ба говийн бүсийн аймгийн ЭМГ, НЭ, ЭМТ, хувийн хэвшлийн эмнэлгийн удирдлагуудын 3 удаагийн сэтгэл ханамжийн судалгаагаар сургалтын үйл ажиллагааг 4.01, мэргэжлийн мэдлэг 3.7, ур чадвар 4.0, харилцаа хандлага 3.3, тэдний 42.8 % нь сургалтын хөтөлбөрийг хангалттай, 43% нь дунд, 14.2% нь хангалтгүй гэж үнэлсэн. 2023 онд ажил олгогчдоос 24 үзүүлэлтээр авсан сэтгэл ханамжийн судалгаагаар бие даан ажиллах чадвар, ачаалал даах чадвар, эерэг зөв хандлага 4-с дээш оноо авсан бол гадаад хэлний мэдлэг 2.99 оноо авсан байна.
- Сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн зохион байгуулсан ажил: “Бидний мэргэжил сайхан” ажил мэргэжлийн уралдаан, “Эмийн олон улсын нэршил” олимпиад, чадавхижуулах сургалт /уян зүү тавих, судас тарилга, эмнэлгийн анхан шатны маягт бөглөх/, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ сургалт, ажлын байрны уулзалт, ярилцага, ажил олгогчдын уулзалт, төгсөлтийн дараах сургалтыг 5 чиглэлээр зохион байгуулж 61 хүнд төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшүүлсэн. 2023 онд 7 хөтөлбөрөөр 7 хүн сувилауын төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалтад сурч байна.

Онцлог зүйл:

- Төгсөгчдийн мөшгөх судалгаа сайн хийдэг.
- Авсан судалгаанд үндэслэн сайжруулах төлөвлөгөөтэй ажилладаг.

Дүгнэлт: Төгсөгчдөөс жил бүр авч байгаа судалгаа нь хөтөлбөр хэрэгжилтийн ахиц дэвшлийг үнэлэх боломж олгож байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Авч байгаа сэтгэл ханамжийн судалгаанд харьцуулалт хийж ахиц, дэвшил, хөтөлбөр хэрэгжүүлэлтийн түвшнийг тогтоож байх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- БМИҮЗ-өөр 2000, 2005, 2018 онуудад байгууллага магадлан итгэмжлэгдсэн.
- “Сувилахуй”/091301/ хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, БМИҮЗ-ийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын “Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг батламжлах” 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоолоор 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлж, сургалтын үйл ажиллагааг эрхэлж байна.

- Багш нар олон улсын сертификаттай 36 сургалтад (2018 онд 11 багш 12 сургалтад, 2019 онд 7 сургалтад 21 багш, 2020 онд 5 багш 8 сургалтад, 2022 онд 1 багш 9 сургалтад) хамрагдсан.
- Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 сарын 14-ний өдрийн 168 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтад “Сувилагч мэргэжилтний хөгжлийн загвар”-ыг баталгаажуулсны дагуу сургалтын хөтөлбөр хэрэгжих 4 жилийн хугацаатай, 120 багц цагийн хөтөлбөрт хамрагдаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Эмнэлгийн сувилагч” бакалаврын зэрэгтэй төгссөн байна гэсний дагуу сувилагч мэргэжилтэн нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой, шалгуурыг хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллах боломжтой.
- 2018-22 оны сувилахуйн бакалавр ангийн төгсөлтийн шалгалтын амжилт 99.5%, чанар 93.6%, үнэлгээний дундаж 96.6%, лицензийн шалгалтыг 100% өгсөн.
- Сувилахуйн бакалавр мэргэжлээр төгсөгчдийн ажил эрхлэлт 2023 оны судалгаагаар 75% нь мэргэжлийн ажил эрхэлж, түүний 64,8% нь 1, 2, 3-р шатлалын эмнэлэгт ажиллаж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөний нотолгоо болж байна.
- 3 төгсөгч гадаадад мэргэжил дээшлүүлж байна.

Онцлог зүйл:

- Гадны 10 гаруй сургууль, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй учир оюутан, багш, төгсөгчдийн дунд мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцуулах, дадлага хийлгэх зэрэг ажлуудыг зохион байгуулдаг.

Дүгнэлт: Байгууллагыг 3 удаа магадлуулсан, хөтөлбөрүүдээ магадлуулж байгаа, төгсөгчдийн лицензийн шалгалтын дүнгээс харахад энэ бүлгийн хэрэгжилт хангалттай байна.

Үнэлгээ:

- Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гэрээ байгуулсан гадны байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөтэй болох, үр дүнг тооцох

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДУГНЭЛТ

| Шалгуур | | Бүрэн хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангаа гүй (0) | Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/ |
|----------------|--|---------------------------|-------------------------------|-----------------------|--|
| 1 | Хөтөлбөрийн төлөвлөлт | + | | | |
| 2 | Сургалтын үйл ажиллагаа | + | | | |
| 3 | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | + | | | |
| 4 | Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | + | | | |
| 5 | Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа | + | | | |
| 6 | Багшийн үйл ажиллагаа | + | | | |
| 7 | Чанарын үнэлгээ, баталгаажилт | + | | | |
| Дүгнэлт | | БҮРЭН ХАНГАСАН | | | |

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

| | | |
|---|--|--|
| Сургуулийн нэр | АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар Анагаах ухааны сургууль | |
| Хөтөлбөрийн нэр | Сувилахуй бакалаврын сургалтын хөтөлбөр | |
| ЗӨВЛӨМЖ | | |
| Шалгуур Хөтөлбөрийн төлөвлөлт | 1. | <ul style="list-style-type: none"> ➤ Нөөц боломжоо ашиглан, сургалт сурталчилгаа сайн хийж, оюутны элсэлтээ нэмэгдүүлэх |
| Шалгуур Сургалтын ажиллагаа | 2. үйл | <ul style="list-style-type: none"> ➤ Суралцагсдыг сургалт-хүмүүжлийн ажил, нийгэмд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх боломжоор хангах, асрамжийн буюу хүүхдийн байгууллагад туслах г.м ажил зохион байгуулах. ➤ Суралцагчдыг үнэлэх шинэлэг аргуудыг оюутны үнэлгээндээ түлхүү хэрэглэх. |
| Шалгуур Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц | 3. | <ul style="list-style-type: none"> ➤ Номын санчдыг орон тоогоор нь ажиллуулах, мэргэшүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах. ➤ Номын сангийн зориулалтын байртай болж, техник тоног төхөөрөмжийг сайжруулах. |
| Шалгуур Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | 4. | <ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулах төсвийг тодорхой болгох. |
| Шалгуур Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ | 5. | <ul style="list-style-type: none"> ➤ Олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцож байгаа оюутнуудыг урамшуулах, сэдэлжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх. ➤ Өөрийн сургуулийн онцлог давуу тал, орон нутгийн дэмжлэг, Засгийн газрын үзүүлдэг дэмжлэгийн талаар сурталчилгаа явуулах, маркетинг хийх. |
| Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа | | <ul style="list-style-type: none"> ➤ Төслийн үр дүнг шаардлагатай салбарт нэвтрүүлж, хэрэгжүүлэх. ➤ Сурагцагчдад судалгааны арга зүй эзэмшүүлэх. |
| Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт | | <ul style="list-style-type: none"> ➤ Сэтгэл ханамжийн судалгаанд харьцуулалт хийж, ахиц, дэвшил, хөтөлбөр хэрэгжүүлэлтийн түвшнийг тогтоож байх. ➤ Гэрээ байгуулсан гадны байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөг нарийвчилж, үр дүнг тооцож байх. |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн “Сувилахуй” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх комисст хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /Б.Оюунбат/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ц.Ганцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ц.Амаржаргал/

Сургуулийн албан бичиг:



АШУУИС

**АШУУИС-ИЙН ДОРНОГОВЬ
АЙМАГ САЛБАР
АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ**

117-1 тоот байшин, Энхтайваны гудамж, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44105,
Утас/факс: (705) 2-21-01
Цахим шуудан: sodg@mnums.edu.mn

2024.02.01 № 13
танай _____ -ны № _____ -т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

“Сувилахуй” бакалаврын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн тайланг уншиж танилцаад хүлээн зөвшөөрч байгааг мэдэгдэж байна.

Цаашид тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтэд анхаарч, сургалтын хөтөлбөрт сайжруулалт хийж ажиллах болно.



ЗАХИРАЛ  М.ОТГОНЧИМЭГ

442400019

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон оюутны нэрс

| | № | Овог нэр | Утасны дугаар |
|------------|----|-------------------------|---------------|
| 1-р дамжаа | 1 | О. Болортунгалаг | 85308525 |
| | 2 | Ү. Номин | 99227486 |
| | 3 | Б. Хулан | 94444757 |
| | 4 | Ц. Лхамноржмаа | 85250211 |
| | 5 | М. Амин-Эрдэнэ | 85681259 |
| 2-р дамжаа | 6 | О. Саранцэцэг | 88565959 |
| | 7 | Ю. Ширмэнтуяа | 99439533 |
| | 8 | С. Уугантуяа | 98706567 |
| | 9 | Т. Төгсжаргал | 94969625 |
| | 10 | О. Хандсүрэн | 95793185 |
| 3-р дамжаа | 11 | Ю. Алтанчимэг | 86575766 |
| | 12 | Б. Ижилцэцэг | 95662327 |
| | 13 | Д. Одбаяр | 95101047 |
| | 14 | А. Цэндсүрэн | 9415475 |
| | 15 | З. Түвшинжаргал | 86118516 |
| 4-р дамжаа | 16 | О. Дашням | 86870318 |
| | 17 | О. Мөнгөнчимэг | 94184806 |
| | 18 | У. Тунгалагнандинэрдэнэ | 96181918 |
| | 19 | А. Ганундрал | 95232317 |
| | 20 | Б. Батжаргал | 95589076 |

II. Ярилцлагад оролцсон ажил олгогчдын нэрс

| | № | Овог нэр | Албан тушаал | Байгууллага | Утасны дугаар |
|--------|----|----------------|---------------------------------|--|---------------|
| цахим | 1 | Д. Батцэцэг | ЭМГ-ын дарга | Дорноговь ЭМГ | 99084093 |
| | 2 | С. Адьяасүрэн | Төвийн эрхлэгч | Дорноговь Өргөн сум ЭМТ | 95519309 |
| | 3 | Б. Алтантөгс | ЭМГ-ын дарга | Дундговь ЭМГ | 99052973 |
| | 4 | Д. Батцэцэг | БОЭТ-ийн дарга | Өмнөговь БОЭТ | 99055387 |
| | 5 | А.Адьяасүрэн | ЭМГ-ын дарга | Сүхбаатар ЭМГ | 99239666 |
| | 6 | С. Дашдорж | БОЭТ-ийн дарга | Дорнод БОЭТ | 99285366 |
| танхим | 7 | Ч. Туул | Сувилахуй хариуцсан мэргэжилтэн | Дорноговь ЭМГ | 94031377 |
| | 8 | О. Уранчимэг | Эмч | Дорноговь “Агатова” өрхийн эмнэлэг | 86298989 |
| | 9 | Ч. Ариунгэрэл | эмч | Дорноговь “Мишээлт манал” өрхийн эмнэлэг | 96536162 |
| | 10 | Т. Сансардулам | эмч | Дорноговь “Ачтан” эмнэлэг | 88066468 |
| | 11 | Б. Наранцэцэг | эмч | Дорноговь “Мансан” эмнэлэг | 99522322 |

III. Ярилцлагад оролцсон төгсөгчдийн нэрс

| | № | Овог нэр | Төгссөн он | Албан тушаал | байгууллага | Утасны дугаар |
|-------|---|----------------|------------|----------------|-------------------------|---------------|
| цахим | 1 | Б. Цолмонгэрэл | 2021 | сувилагч | ДОА БОЭТ хүүхдийн тасаг | 96619125 |
| | 2 | Б.Цэрэнсугар | 2020 | СЗ-ын сувилагч | Дундговь Дэрэн сум ЭМТ | 80260627 |
| | 3 | А. Мягмарсүрэн | 2020 | сувилагч | Дорноговь НЭ | 85589081 |
| | 4 | Н. Ууганболор | 2019 | сувилагч | СҮА Халзан-Уул ЭМТ | 89471989 |

| | | | | | | |
|--------|----|-------------------|------|----------|--------------------------|-----------|
| | 5 | Б. Мөнхцэцэг | 2019 | сувилагч | ХЭА НЭ | 80650616 |
| | 6 | Б. Алтанцэцэг | 2019 | сувилагч | ДГА Мишээлт мана ӨЭМТ | 89033068 |
| | 7 | М. Мөнхтуяа | 2019 | сувилагч | ДГА Айраг сум ЭМТ | 89999073 |
| танхим | 8 | А. Эрдэнэчимэг | 2021 | эмч | ДГА 14-р цэцэрлэг | 96850529 |
| | 9 | Г. Отгонбаяр | 2021 | сувилагч | ДГА НЭ | 96135254 |
| | 10 | Ү. Гандирмаа | 2019 | сувилагч | ДГА Мишээлт мана ӨЭМТ | 90737047, |

IV. Ярилцлагад оролцсон багш нар

| № | Овог нэр | Албан тушаал | Эрдмийн зэрэг цол | Ажил ласан жил | Утасны дугаар | Мэйл хаяг |
|----|------------------------|-----------------------------|----------------------------------|----------------|---------------|----------------------------|
| 1. | Цэнгэл Дэлгэрмаа | Монгол хэлний багш | ХШУ-ы магистр | 12 | 8901 7477 | delgermaa@mnums.edu.mn |
| 2. | Ерөөлт Өнөболд | Нийгмийн эрүүл мэндийн багш | НЭМШУ-ы магистр | 9 | 9523 2598 | Unubold@mnums.edu.mn |
| 3. | Шаравдорж Отгонтуяа | Химийн багш | Байгалийн ШУ-ы магистр | 17 | 9913 9551 | otgontuya@mnums.edu.mn |
| 4. | Шийхар Энхмаа | Биологийн багш | Биологийн ухааны магистр | 14 | 9100 2989 | enkhmaa@mnums.edu.mn |
| 5. | Цэгмид Сарантуяа | Эмнэлзүйн лабораторийн багш | АУ-ы доктор, Клиникийн профессор | 39 | 9915 4927 | Sarantuya.ts@mnums.edu.mn |
| 6. | Адъяа Нямдаваа | Физиологийн багш | БС-ын магистр | 16 | 9144 2629 | nyamdavaa@mnums.edu.mn |
| 7. | Чойбаатар Энхжаргал | Түүхийн багш | БУ-ны магистр | 17 | 9136 0126 | Enkhjargal.ch@mnums.edu.mn |
| 8. | Цоо Наранбаатар | Биеийн тамирын багш | Спортын мастер | 24 | 9017 7188 | naranbaatar@mnums.edu.mn |
| 9. | Батхуяг Батцэцэг | Гадаад хэлний багш | ХШУ-ы магистр | 17 | 9906 7666 | Battsetseg.b@mnums.edu.mn |

| | | | | | | |
|-----|---------------------------|---|--|----|--------------|---|
| 10. | Бэхбат Наранжаргал | Сувилахуйн багш | БУ-ы магистр | 31 | 9905 4961 | Naranjargal@ mnums.edu.mn |
| 11. | Ганхүү Энхцэцэг | Сургалтын албаны ахлах арга зүйч | АУ-ы магистр, клиникийн профессор | 30 | 9928 1703 | Enkhtsetseg.g@mnums.ed u.mn |
| 12. | Батхуяг Одончимэг | Халдварт өвчин судлалын багш | БУ-ы магистр | 15 | 9663 5530 | odonchimeg@ mnums.edu.mn |
| 13. | Дамжин Баатар | Хими, биологийн багш | Биологийн ухааны доктор, дэд профессор | 44 | 9914 3703 | baatar@ mnums.edu.mn |
| 14. | Дэлгэрсайхан Түмэнбаяр | Арьс судлалын багш | ТУ-ы магистр, ахлах зэрэг | 13 | 9609 5980 | Tumenbayar.d@mnums.ed u.mn |
| 15. | Отгонбаатар Энхчулуун | Сургалтын албаны арга зүйч | БУ-ы магистр, ахлах зэргийн сувилагч | 15 | 9661 1440 | enkhchuluun@mnums.edu. mn |
| 16. | Жамбал Батчулуун | Тархвар судлалын багш | АУ-ы магистр | 34 | 9907 8248 | batchuluun@mnums.edu.m n |
| 17. | Моононхүү Отгон | Сувилахуйн багш | БУ-ы магистр | 28 | 9635 5111 | Otgon.m@mnums.edu.mn |
| 18. | Дорждэрэм Мөнхцэцэг | Сувилахуйн багш | ЭМБУ-ы магистр | 17 | 9083 4455 | Munkhtsetseg.do@mnums. edu.mn |
| 19. | Дорж Долгорсүрэн | Сэтгэцийн эрүүл мэндийн багш | ТУ-ын магистр | 17 | 9902 2964 | <u>Dolgorsuren.do@mnums.e du.mn</u> |
| 20. | Монголжав Чулуунсүх | Сувилахуйн багш | ЭМБУ-ы магистр | 13 | 8037 0409 | chuluunsukh@ mnums.edu.mn |